

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-6
1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/	4-6

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 05 дугаар сарын 16-ны өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 34 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Алдаржавхлан, П.Батчимэг, Х.Ганхуяг, М.Мандхай,
А.Ундраа, О.Цогтгэрэл, С.Цэнгүүн, М.Энхцэцэг;
Эмнэлгийн чөлөөтэй: Н.Батсүмбэрэл, Х.Баттулга;
Тасалсан: Б.Жаргалан.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Тогтоолын төслийн талаар Байнгын хорооны дарга Р.Сэддорж танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, Ш.Бямбасүрэн, М.Бадамсүрэн нар үг хэлэв.

Р.Сэддорж: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	4
Бүгд:	14

71.4 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, Р.Сэддорж, Д.Энхтүвшин нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 92.9 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар М.Бадамсүрэн, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, Р.Батболд, О.Батнайрамдал, Г.Лувсанжамц, Л.Соронзонболд,

Г.Очирбат, Ш.Бямбасүрэн, Г.Ганбаатар, Б.Мөнхсоёл, Д.Энхтүвшин нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 09 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 08 минут үргэлжилж, 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр 09 цаг 42 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр,
Баасан гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхимд 09 цаг 34 минут

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая аа.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн, Батболд, Батнайрамдал, Батшугар, Бямбасүрэн, Ганбаатар, Лодойсамбуу, Лувсанжамц, Мөнхсоёл, Сайнзориг, Соронзонболд, Найдлаа, Энхтүвшин, Сэддорж нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна аа.

Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 56 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулна аа.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье ээ.

Байнгын хорооны тогтоол.

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэж Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Гишүүдийн нэрсийг эхлээд дуудъя.

Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн, Батбаяр, Батболд, Батнайрамдал Лувсанжамц, Соронзонболд, Очирбат, Бямбасүрэн, Г.Ганбаатар, Энхтүвшин нарын гишүүд ажлын хэсэгт орохоор саналаа ирүүлсэн байна аа.

Ажлын хэсгийн даргыг ярилцана.

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа авах мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг хуралдаанд оролцуулахыг ажлын хэсэгт зөвшөөрсүгэй гэсэн ийм тогтоолын төслийг хэлэлцүүлж байна аа.

Мөнхсоёл гишүүний микрофоныг нээе.

Б.Мөнхсоёл: Ажлын хэсэгт өөрийнхөө нэрийг оруулах саналтай байна. Бас Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооныхоо хүрээнд бас харъя гэж бодлоо.

Р.Сэддорж: Ингээд 11 гишүүн байна. Ажлын хэсгийн даргад бол Бямбасүрэн, Бадамсүрэн гэсэн 2 гишүүн яригдаж байна.

Та 2 одоо хоорондоо яриад саналаа хэлчих. Яг би больё гээд. Бямбасүрэн гишүүний микрофоныг нээе.

Ш.Бямбасүрэн: Би ирэх 7 хоногийн хувьд бараг 1 дэх, 2 дахь, 3 дахь өдөр нь чөлөөтэй байгаа учраас ажлын хэсэг даргалах боломжгүй байгаа.

Тэгэхээр Бадамсүрэн гишүүнийг ажлын хэсэг дээр дэмжээд явчихъя. Бадамсүрэн гишүүн саналаа хэлье.

М.Бадамсүрэн: Өөр ажлын хэсгийн гишүүдээс өөр одоо ахалж ажиллая гэсэн саналтай хүн байвал хүндэтгэж хүлээж авна. Өөр одоо саналаа өгсөн хүн байхгүй тэгээд Бямбасүрэн гишүүн маань одоо саналаа илэрхийлж бас одоо намайг ахлуулъя гэсэн санал илэрхийлж өөрийнхөө нэрийг татаж байгаа учраас өөр саналтай хүн байхгүй бол ахлахад татгалзах зүйлгүй ээ.

Р.Сэддорж: Өөр саналтай гишүүд байхгүй байна. Ингээд тогтоолын төслийг гишүүдийн нэрсийг дахин танилцуулъя. Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн, ажлын хэсгийн гишүүд Улсын Их Хурлын гишүүн Батболд, Батбаяр, Батнайрамдал Лувсанжамц, Соронзонболд, Очирбат, Бямбасүрэн, Г.Ганбаатар, Энхтүвшин, Мөнхсоёл нарын гишүүд.

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа авах мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг хуралдаанд оролцуулахыг ажлын хэсэгт зөвшөөрсүгэй.

Эдийн засгийн байнгын хорооны дарга гэсэн энэхүү тогтоолын төсөлтэй холбогдуулж гишүүд асуулт асууж, санал хэлэх гишүүд байна уу. Нэрсээ өгье. Алга байна. Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа.

Санал хураалт явуулж эхэлье.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулна аа.

Миний бас юу орж ирсэнгүй 71.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин, Мөнхсоёл, Сэддорж нарын дэмжсэн саналаар протокол тэмдэглэж өгье.

Санал хураалт явуулж дууслаа.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаа идэвхтэй оролцсон гишүүд ажлын хэсэгт баярлалаа.

09.42 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА